

Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газар
2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

№	Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж	Төсөв	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин		Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/	Гүйцэтгэл-ийн хувь	
					Эхний хагас жил	Сүүлийн хагас жил		Өөрийн үнэлгээ	ХШҮ
Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт, арга хэмжээ									
1.1.	Боловсрол, шинжлэх ухааны салбарын гадаад харилцаа, хамтын ажиллагааг хөгжүүлэх, өргөжүүлэх, гадаад улсад хүний нөөц бэлтгэх, олон улсын төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлэх;	850,000,000 сая төгрөгө	-	-	-		Боловсрол, шинжлэх ухааны яам, Япон улсын Шинагава дүүрэг, “ЖАЙКА” Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээ, бэлтгэл ажлыг зохион байгуулж талууд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. -Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар БНБУ-	100%	70%

						ын Ерөнхийлөгч А.Г.Лукашенко Монгол Улсад 2024 оны 06 дугаар сарын 01- 04-ний өдрүүдэд төрийн айлчлал хийх болсонтой холбогдуулан хамтран ажиллах 4 баримт бичгүүдийг боловсруулах, орчуулах, холбогдох байгуллагуудад илгээж, хянуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. - ОМӨЗО-ны Засгийн газрын тэтгэлэгт оюутны тоог 20-оор нэмэгдүүлээ. - Pearson English хөгжлийн хөтөлбөр хэрэгжиж, 70 сая евро төсөл эхлүүлэх ажлыг бэлтгэл ажлыг ханган ажилласан. Кембрижийн сургалтын хөтөлбөрийг 2024- 2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх болон ЕБС-д		
--	--	--	--	--	--	---	--	--

						хэрэгжүүлэхээр болсон. Монгол оюутнуудад олгох Chevening тэтгэлгийн квотыг 7+10 буюу 17хүртэл нэмэгдүүлсэн. - Финландын “Heureka” төвтэй хамтран ажиллах, Монголд баригдаж буй шинжлэх ухааны паркийн музей, хүүхэд залуучуудад зориулсан шинжлэх ухааны туршилтын төвийг байгуулахад зөвлөх үйлчилгээ авахаар тохирлоо. Эстони Улстай дунд сургуулийн ахлах багш, сургуулийн менежер харилцан солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ярилцлаа. Эстонийн боловсролын чанарын баталгаажуулалтын НАКА /Estonian Quality Agency for Education/		
--	--	--	--	--	--	--	--	--

						байгууллагатай хамтран ажиллах хүсэлтээ албажуулж хүргүүлэхээр боллоо. Гэрээ, хэлэлцээрийн хүрээнд үргэлжлэх: 1. 2023-2024 оны хичээлийн жилд 18 тэтгэлэгт хөтөлбөрт 1200-1300 Монгол Улсын иргэд суралцаж байна. 2. Энэ хичээлийн жилд Гадаад улсын (БНХАУ, ОХУ, Польш, Вьетнам, Унгар, Чех, Лаос, Энэтхэг)-ын 260 оюутан дээд боловсролын байгууллагад суралцаж байна. 3. 120 оюутан нэмэлтээр сургах чиглэлээр (Киргиз, БНХАУ, БНСУ, ХБНГУ-DAAD) гэрээ байгуулсан буюу хэлэлцээрийн түвшинд байна. 4. Гадаад улсад суралцаж буй оюутнуудад		
--	--	--	--	--	--	--	--	--

							амьжиргааны зардал шийдвэрлүүлж ажилласан.		
1.1.-1	Англи, Америк, Канад, Австрали зэрэг улсуудын Элчин сайд нар болон холбогдох төлөөллийг хүлээн авч уулзах уулзалтуудыг зохион байгуулах	2024 оны батлагдсан төсөв	Зохион байгуулсан уулзалтын тоо, боловсруулж, батлуулсан гэрээ, хэлэлцээр, баримт бичгийн тоо	2023 онд зохион байгуулсан Олон Улсын хурал, уулзалт	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	-Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх- Амгалан Канад Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Сандра Шуфаниг хүлээн авч уулзах уулзалтыг зохион байгуулсан. Уулзалтаар хоёр улсын боловсрол, шинжлэх ухааны салбарын хамтын ажиллагааны ололт амжилт, цаашдын хамтын ажиллагааны талаар санал солилцов. Талууд “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих арга хэмжээ”-ний хүрээнд ЕБС-ийн англи хэлний багш нарын мэргэжлийн ур чадварыг сайжруулах, сургагч багш, экспертүүдийг	100%	100 %

						урих, Канад улсад богино болон дунд хугацаанд суралцуулах боломжийн талаар ярилцсан юм. Элчин сайд Сандра Шуфани Канадын Засгийн газраас хэрэгжүүлдэг “Technical Assistance Partnership” хөтөлбөрийн хүрээнд дээр дурсан ажлуудыг хэрэгжүүлэх, 200 мянга хүртэлх ам.долларын санхүүжилт олгох боломжтойг мэдэгдэв. - Засгийн газрын тогтоолоор баталсан “Бүх нийтийн англи хэлний суралцахуйг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын англи хэлний боловсролыг сайжруулах хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгууллаа.		
--	--	--	--	--	--	---	--	--

						Энэхүү арга хэмжээг Боловсрол, шинжлэх ухааны яам, Монгол Улсад суугаа Америкийн Нэгдсэн улсын Элчин сайдын яамтай хамтран зохион байгуулсан юм. Тус уулзалтад АНУ, Их Британи, Канад, Австрали, Энэтхэг, Франц зэрэг улсын Элчин сайд нараас гадна англи хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлдэг улсууд болох Чех, Польш, Солонгос зэрэг улсын Элчин сайд нар, Энхтайвны корпус, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийг ивээх сан зэрэг олон улсын байгууллагын удирдлагууд оролцлоо. - ИБУИНВУ-ын Элчин сайд Хатагтай Фиона		
--	--	--	--	--	--	---	--	--

							Блайт болон сайд Л.Энх-Амгалан 5 дугаар сарын 14-ны өдөр албан уулзалтыг зохион байгууллаа. Тус уулзалтаар Англи хэлний PEARSON хөтөлбөрийг өргөжүүлэхэд тус улсын зүгээс үе шаттайгаар хамтран ажиллахаа илэрхийлсэн бөгөөд 3-7 дугаар ангийн сурагчдад PEARSON хөтөлбөрийг нэвтрүүлэх, Бага ангийн англи хэлний багш нарыг мэдлэг чадварыг дээшлүүлэх, Орон нутгийн болон төвийн боловсролын байгууллагын албан хаагчдыг сургалтад хамруулах мэргэшлийг дээшлүүлэхээр тохиров.		
1.1.2	Яамны удирдлагуудын олон улсын	2024 оны батлагдсан төсөв	Зохион байгуулсан уулзалтын тоо,	2023 онд зохион байгуулсан	1. Олон Улсын хурал, уулзалт,	1. Олон Улсын хурал, уулзалт,	-Холбооны Бүгд Найрамдах Герман Улсын	100%	100 %

	байгууллагууд, элчин сайдын яамдын төлөөлөгчидтэй дотооддоо хийх уулзалтыг зохион байгуулах		байгуулсан гэрээ, батлуулсан баримт бичгийн тоо	Олон Улсын хурал, уулзалт	сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Боловсрол судалгааны яамны төлөөлөгчидтэй Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан 2024 оны 5 дугаар сарын 15-нд хүлээн авч уулзсан албан уулзалтын бэлтгэл ажлыг зохион байгуулсан. Уулзалтын үеэр Монгол Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургуулийн өргөтгөлийн төсөл бусад боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлж буй төсөл хөтөлбөрүүдийн талаар санал солилцож, Германы судалгааны сангаас хэрэгжүүлж буй “Хөгжиж буй улс орнуудын хөтөлбөр”-т Монгол Улсын судлаач, эрдэмтдийг		
--	---	--	---	---------------------------	---	---	--	--	--

						хамруулахаар тохиролцсон. МУИС-д ХБНГУ-ын Боловсрол, судалгааны яамны төлөөлөгчидтэй төрийн өмчит 6 их сургуулийн төлөөлөл бүхий илтгэгч нар оролцсон дугуй ширээний уулзалтыг зохион байгуулсан. - Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал АНУ-ын Төрийн департаментын Боловсрол, соёлын асуудал эрхэлсэн товчооны Төрийн нарийн бичгийн даргын бодлого хариуцсан орлогч Рафик Мансурыг 2024 оны 5 дугаар сарын 20-ны өдөр хүлээн авч уулзсан уулзалтын бэлтгэл ажлыг хангасан. Уулзалтаар хоёр орны боловсрол,	
--	--	--	--	--	--	---	--

						шинжлэх ухааны салбар дахь хамтын ажиллагаа, хамтарсан хөтөлбөрүүдийн тухай санал солилцсон. - Боловсрол шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Бүгд Найрамдах Энэтхэг Улсаас Монгол Улсад суугаа элчин сайд Атул Малхари Готсурвэтэй 2024 оны 5 дугаар сарын 3-нд уулзсан албан уулзалтыг зохион байгуулсан. Албан уулзалт өндөрлөсний дараа, Монгол Энэтхэгийн найрамдлын сургууль, Атал Бахари Важпайн нэрэмжит Мэдээллийн технологийн боловсрол, Аутсорсингийн төвийн барилгын ажлын явцтай		
--	--	--	--	--	--	---	--	--

							танилцсан. - Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Бутаны хаант Улсын Боловсролын яам хоорондын харилцан ойлголцлын санамж бичгийн төслийг 2024 оны 5 дугаар сарын 29-ний өдөр боловсруулж, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газарт хянуулахаар хүргүүлсэн.		
1.1.3	БНХАУ-ын Шанхай хотод зохион байгуулагдах “Цахим боловсролыг хөгжүүлэх” сэдэвт хуралд оролцох үйл ажиллагааг зохион байгуулах	2024 оны батлагдсан төсөв	Айлчлалын бэлтгэл ажил, зохион байгуулалтын дэг	2023 онд зохион байгуулсан Олон Улсын хурал, уулзалт	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан болон БНХАУ-ЫН Шанхай хотод хийсэн айлчлалыг зохион байгууллаа. Боловсрол, шинжлэх хааны сайд Л.Энх-Амгалан Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Боловсролын	100%	100 %

					ажилласан байна.	байна.	сайд Хуай Жиньпөнтэй албан ёсны уулзалт хийлээ. Сайд Хуай Жиньпөн Дэлхийн дижитал боловсролын бага хуралд өөрийн биеэр хүрэлцэн ирж оролцсонд талархал илэрхийлээд өнгөрсөн оны 4 дүгээр сард солилцсон ноот бичгийн хүрээнд боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтын ажиллагаагаа илүү өргөжүүлэхийг хүсэж байгаагаа илэрхийллээ. Мөн Юнескогоос боловсролын салбарт цахим шилжилтийг амжилттай хэрэгжүүлж буй онцлох 5 орны нэгээр Монгол Улс нэрлэгдсэн, Күнзийн 4 институт, 7 танхимын үйл ажиллагааг Хуай Жиньпөн сайд		
--	--	--	--	--	---------------------	--------	---	--	--

						сайшаасан байна.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” хөтөлбөр цөлжилтийн эсрэг чухал үйл ажиллагаа бөгөөд экологи, ногоон байгууламжийн чиглэлээр хүний нөөцийг мэргэжлийн болон дээд боловсролын салбарт бэлтгэх, энэ чиглэлээр 2+2, 3+1 хөтөлбөрийг хамтран хэрэгжүүлэх, дундын лаборатори байгуулах; Хятад улсад 6600 гаруй Монгол оюутан залуус суралцаж байгаа бөгөөд 3 оюутан тутмын нэг нь Хятадын Засгийн газрын тэтгэлгээр суралцаж байна. Монгол Улсын Ерөнхийлөгчийн “Илгээлт 2100” хөтөлбөрийн хүрээнд		
--	--	--	--	--	--	---	--	--

						тэтгэлэгтэй суралцах оюутны тоог нэмэгдүүлэх, хэлний бэлтгэлийг суралцах хугацаа, тэтгэлэгт оруулах; Ерөнхий боловсролын салбарт 5 жилийн богино хугацааны хөтөлбөр хэрэгжүүлж, жил бүр ерөнхий боловсролын сургуулийн 100 удирдах ажилтан, 100 багшийг менежмент, цахим ур чадварыг сайжруулах сургалт, үйл ажиллагаанд хамруулж, сайн туршлагыг түгээн дэлгэрүүлэх; Бээжингийн их сургууль, Шандуны их сургууль, МУИС, ШУТИС зэрэг их дээд сургуулиудын хамтын ажиллагааг илүү өргөжүүлэх, харилцан дэмжлэг үзүүлэх; Дижитал боловсролын чиглэлээр тоног		
--	--	--	--	--	--	---	--	--

							төхөөрөмж, дэд бүтцийг сайжруулах чиглэлээр дэмжлэг үзүүлэх зэрэг асуудлыг ярилцлаа. Засгийн газар хоорондын хэлэлцээрээр боловсролын баримт бичиг, боловсролын зэргийг талууд харилцан хүлээн зөвшөөрлөө.		
1.1.4	БШУ-ны дэд сайдын Бүгд Найрамдах Беларусь улсад, БШУ-ны сайдын Финлянд, Эстони улсад хийх айлчлалыг зохион байгуулах	2024 оны батлагдсан төсөв	Гадаад харилцааны арга хэмжээний хэрэгжилтийн тоо	2023 онд зохион байгуулсан Олон Улсын хурал, уулзалт	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Худалдаа Эдийн засаг, шинжлэх ухаан техникийн хамтын ажиллагааны Бүгд Найрамдах Беларусь улс, Монгол улсын Засгийн газар хоорондын комиссын 7 дугаар хуралдаанд оролцох Боловсрол, шинжлэх ухааны дэд сайдын айлчлалыг зохион байгуулсан. Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр тэргүүтэй	100%	100 %

						бүрэлдэхүүн нь 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 27-ны өдрүүдэд тус улсад айлчлал хийж БНБУ-ын Боловсролын сайд А.И.Иванецтэй болон бусад холбогдох талуудын төлөөлөлтэй уулзалт хийж, шинлэх ухааны технологийн дэд комиссын хуралдаанд оролцсон. Талууд шинжлэх ухаан, технологийн салбарт хөдөө аж ахуй, ойн нөхөн сэргээлт, үржүүлэг, түүх, археологийн судалгааны салбар дахь хоёр орны эрдэмтдийн хамтын ажиллагааг эхлүүлэх, идэвхжүүлэхэд дэмжих чиглэлээр хамтарч ажиллахаар тохиролцсон болно. 2024 оны		
--	--	--	--	--	--	--	--	--

						06-р сард тус улсаас албан айлчлал хийж, Боловсрол, шинжлэх ухааны салбарт хамтран ажиллах 4 баримт бичигт гарын үсэг зурлаа. -БШУ-ы сайдын Финлянд болон Эстони улсад албан айлчлах томилолтыг амжилттай зохион байгуулав. БШУ-ы сайд болон томилолтын бүрэлдэхүүн болох яамны БНБТГ, ГХХАГ-ын дарга, БЕГ-ын удирдлагууд, МУБИС-ын захирал нь 03 дугаар сарын 21-29-ний өдрүүдэд Бүгд найрамдах Эстони, Финлянд улсуудын Боловсрол, эрдэм шинжилгээний сайд, холбогдох нэгж байгууллага, их сургууль цэцэрлэгтэй танилцан хамтын ажиллагааг өргөжүүлэн		
--	--	--	--	--	--	--	--	--

						ажилласан байна. Томилолтоор БШУ-ы сайд Л.Энх-Амгалан дараах байгууллага, төлөөлөгч нартай хийх албан уулзалтыг амжилттай зохион байгуулав. - Эстони улсын Боловсрол, эрдэм шинжилгээний сайд Кристина Калласт - Финланд улсын Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Ярно Сиряала - Финланд улсын Гадаад харилцааны яамны Боловсролын асуудал хариуцсан элчин сайд Саннамари Ванамо - Финланд улсын Боловсрол, соёлын яамны дэд сайд Анита Лехикойнен Мөн БЕГ-ын дарга болон МУБИС-ийн удирдлага нар нь		
--	--	--	--	--	--	--	--	--

							тус улсын боловсрол хариуцсан агентлаг, Турку их сургуультай албан уулзалтыг хийж хамтын ажиллагааны санамж бичиг байгуулах ажлыг зохион байгуулав. Хавсралт: 1 файл		
1.1.5	Бүх түвшний боловсролын байгууллагын багш нарыг гадаад улсад туршлага судлах богино, дунд хугацааны сургалтад хамруулах	2024 оны батлагдсан төсөв	Сургалтад хамрагдсан багшийн тоо, зохион бйагуулсан арга хэмжээний тоо	2023 онд зохион байгуулсан Олон Улсын хурал, уулзалт	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	-Боловсрол, шинжлэх ухааны яам, НҮБ-ын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага (UNESCO)-ын ивээл дор Ази-Номхон далайн орнуудын “Багш солилцоо”-ны хөтөлбөрийг БНСУ-тай хамтран хэрэгжүүлж байна. Тус хөтөлбөрийн хүрээнд Монгол улсаас ерөнхий боловсролын сургуулийн 10 багш БНСУ-ын сургуулиудад 2024.04.16 -ны өдрөөс эхлэн тус	100%	100 %

						улсад 3 сарын хугацаатай ажиллах үйл ажиллагааг зохион байгуулж ажилласан. Солонгос улсаас хүрэлцэн ирж ерөнхий боловсролын 5 сургуульд ажиллаж буй 10 багшийг чиглүүлэн, зохион байгуулалтаар ханган ажиллаж байна. Түүнчлэн Солонгос улсаас Монгол улсад ажиллаж байгаа багш нарын багшлах болон бусад үйл ажиллагаанд тус улсын Боловсролын яамнаас мэргэжилтнүүд ирж хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хамтран ажиллаж байна. Багш солилцооны хөтөлбөрт хамрагдсан багш нар харилцан туршлага солилцож,		
--	--	--	--	--	--	--	--	--

						бусдаас суралцахын зэрэгцээ хоёр улсын түүх соёл, ёс уламжлалаа түгээн дэлгэрүүлэх өргөн боломж нээгдэж байна. -БНХАУ-ын ӨМӨЗО-ы Боловсролын танхимийн урилгаар тус орны Бугат хотод 03 дугаар сарын 24-29-ний өдрүүдэд орон нутгийн МСҮТ-ийн багш, арга зүйчдийг хамруулсан ний 41 хүнийг сургалтад хамруулав. Энэхүү сургалт нь нийт 5 өдрийн Бугат хотын Мэргэжлийн болон техникийн сургуулиудаар зочлон туршлага солилцох мөн хэлэлцүүлэг хийх зорилготой бөгөөд Булган хотын МСҮТ-ийн захирал багш нар нь өөрсдийн үйл ажиллагааг танилцуулан		
--	--	--	--	--	--	---	--	--

							санал солилцон ажилласан. Бүгд Найрамдах Турк улсад 2024 оны 2 удаагийн “Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг боловсролд тэгш хамруулах нь” сэдэвт сургалтад хамрагдах, тус улсын боловсролын байгууллагуудын болон хүүхэд хөгжлийн төвүүдийн үйл ажиллагаатай танилцах, туршлага судлах зорилгоор ЕБС-ын 50 багшийг хамруулах ажлыг зохион байгуулж ажилласан.		
1.1.6	“ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН ШАТАЛСАН СУРГАЛТЫН ТОГТӨЛЦӨӨ” ХБНГУ-тай хамтарсан төслийг хэрэгжүүлэх	2024 оны батлагдсан төсөв	Батлагдсан төсөл, хөтөлбөр, хэрэгжүүлж, зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, чанар, үр дүн	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн	Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль төслийг хэрэгжүүлэх тухай Монгол Улсын Боловсрол, шинжлэх ухааны яам, Германы Олон улсын хамтын	100%	100%

						байна.	ажиллагааны нийгэмлэг хоорондын хэлэлцээр"-т Боловсрол, шинжлэх ухааны сайд Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, Германы Олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэгийн Зүүн Азийн бүсийн захирал Торстен Гийлэр нар гарын үсэг зурах арга хэмжээг зохион байгуулсан. Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС)-ийг хоёр улсын Засгийн газрын санаачилгаар 2013 онд үүсгэн байгуулсан. Дээрх хэлэлцээрээр ХБНГУ-ын болон олон улсын, үндэсний дээд боловсролын байгууллагатай нягт хамтран ажиллаж, олон улсын стандартад нийцсэн,		
--	--	--	--	--	--	--------	---	--	--

							туршлагад суурилсан сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, нарийн мэргэжлийн боловсон хүчин бэлтгэх, мөн шинжлэх ухааны шинэ мэдлэг, туршлага олгох үйл ажиллагааг үргэлжлүүлэх боломж бүрдлээ. Хэлэлцээрт зааснаар ХБНГУ-ын Засгийн газраас уг төслөөр 4 сая еврогийн санхүүжилтийг олгоно.		
1.1.7	Монгол улсад хэрэгцээтэй эмч, сувилагч, судлаач, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэх БНСУ-тай хамтарсан төсөл	-	Зохион байгуулсан үйл ажиллагааны тоо, төсөлд хамрагдах эмч, сувилагч, судлаач, эмнэлгийн мэргэжилтнүүдийн тоо	2023 оны төсөл, хөтөлбөр	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.	Монгол улсад хэрэгцээтэй эмч, сувилагч, судлаач, эмнэлгийн мэргэжилтнүүдийг бэлтгэх БНСУ-тай хамтарсан төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна.	30%	30%
1.1.8	“ИНЖЕНЕР, ТЕХНОЛОГИЙН	2024 оны батлагдса	Төсөлд хамрагдаж	Өмнөх онд бакалаврт-25,	Салбарын болон яамны	Хэрэгжилтэд дэмжлэг	1. “Инженер, технологийн дээд	100%	50%

	ДЭЭД БОЛОВСРОЛ” төслийн II үе шатны үйл ажиллагааг хэрэгжүүлэх, зохион байгуулах	н төсөв	суралцах иргэний тоо	магистр, докторын зэрэгт -90	гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	үзүүлсэн байна.	боловсрол” төслийн хамтарсан судалгааны хөтөлбөрийн хүрээнд Монгол Улсын их сургууль, Шинжлэх ухаан, технологийн их сургууль, Хөдөө аж ахуйн их сургуульд ажиллаж буй судалгааны багуудад 2023- 2024 оны хичээлийн жилд нийт 338.0 сая төгрөгийн судалгаа дэмжих санхүүжилтийн хуваарь батлах, “Инженер, технологийн дээд боловсрол” төслийн Зэргийн бус сургалтын хөтөлбөрт ХААИС-иас 2024 оны эхний хагас жилд хамрагдан Япон Улсад суралцах багш, судлаач нарын нэрсийг батлах тухай”, Инженер, технологийн дээд боловсрол”		
--	---	---------	-------------------------	------------------------------------	---	--------------------	--	--	--

							төслийн бакалаврын хамтарсан хөтөлбөрийн хүрээнд 2021 оны 04 дүгээр сараас эхлэн Япон Улсад 2022-2023 оны хичээлийн жилд хангалтгүй суралцаж сургуулиа төгсөх боломжгүй болсон иргэдийн асуудлыг шийдвэрлэх зэрэг төслийн удирдах хорооны хурлуудад тус тус оролцож чиглэл өгч, хамтран ажилласан.		
1.1.9	БҮХ НИЙТИЙН АНГЛИ ХЭЛНИЙ СУРАЛЦАХУЙГ ДЭМЖИХ АРГА ХЭМЖЭЭ (2022-2025) -г удирдлага, зохион байгуулалтаар хангах	2024 оны батлагдсан төсөв	Арга хэмжээнд хамрагдсан иргэн, суралцагчийн тоо, зохион байгуулсан үйл ажиллагаа	2023 оны төсөл, хөтөлбөр	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.	Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.	2024 оны 03 дугаар сарын 06-ны өдөр АНУ-ын Элчин сайдын яамтай хамтран АНГЛОФОН БУЮУ АНГЛИ ХЭЛТЭЙ УЛС ОРНУУДЫН ЭЛЧИН САЙД НАРЫГ урин Засгийн газрын тогтоолоор баталсан “Бүх нийтийн англи хэлний	100%	100 %

						суралцахуйг дэмжих хөтөлбөр”-ийн хүрээнд Монгол Улсын англи хэлний боловсролыг сайжруулах хэлэлцүүлэг уулзалтыг зохион байгуулав. Тус уулзалтад АНУ, Их Британи, Канад, Австрали, Энэтхэг, Франц зэрэг улсын Элчин сайд нараас гадна англи хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлдэг улсууд болох Чех, Польш, Солонгос зэрэг улсын Элчин сайд нар, Энх тайвны корпус, Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хөгжлийн хөтөлбөр, Хүүхдийг ивээх сан зэрэг олон улсын байгууллагын удирдлагууд оролцов. Уулзалтад БШУ-ы сайд болон Төрийн нарийн бичгийн даргын		
--	--	--	--	--	--	---	--	--

							албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Б.Батцэцэг, Боловсролын нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газрын дарга П.Оюунаа, Гадаад харилцаа, хамтын ажиллагааны газрын дарга Ш.Нарантуяа нар оролцов. П.Оюунаа дарга нийт төлөөлөгчдөд Монгол улсын Боловсролын салбарт хэрэгжиж эхлээд буй англи хэлийг дэмжих арга хэжээний хүрээнд хийгдэж буй ажил мөн цаашид олон улсын байгууллагатай хамтарч ажиллах саналыг танилцуулав. Хавсралт: 1 файл		
1.1.1 0	Монгол-Оросын хамтарсан сургуулиудын үйл ажиллагааг үргэлжүүлэн дэмжих	2024 оны батлагдсан төсөв	ОХУ-ас ажиллаж буй багшийн тоо, стандарт хөтөлбөрөөр суралцаж буй суралцагчийн	2023 оны төсөл, хөтөлбөр	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр	ОХУ болон Монгол улсын стратегийн түншлэл, боловсролын салбарын хамтын	100%	100%

			тоо, зохион байгуулагдсан арга хэмжээний тоо		олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.	ажиллагааны хүрээнд Улаанбаатар хотын 162 дугаар сургуулийг ОХУ- ын боловсролын стандартад үе шаттайгаар шилжүүлэх хэлэлцээр хийгдэж, 2023 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн Засгийн газрын хуралдаанд 162 дугаар сургуулийн Орос хэлний сургалттай болгохоор “Хамтарсан сургууль байгуулах тухай” тогтоол батлагдсан. ОХУ- аас ирсэн багш нарын амьдрах байр, орон сууцны зардал, унааны зардлыг СХД буюу орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, аюулгүй байдлыг хангах үүднээс багш нарыг ажилдаа ирэх очиход нь сургуулийн өөрийн		
--	--	--	---	--	---	---	--	--	--

						автомашинаар үйлчилж байна. БШУЯ-аас холбогдох байгууллагад уламжилж, багш нарын оршин суух зөвшөөрлийг гаргаж өгсөн болно. Түүнчлэн БШУЯ-аас сургуулийн сургалтын орчин, хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэн багш бүрд компьютер, анги бүрд ухаалаг самбар болон бусад тоног төхөөрөмжөөр бүрэн хангасан. Багш нарын байрны барилгын газар болон, барилгын санхүүжилтийн эх үүсвэрийг улсын төсөвт тусган, бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. БШУЯ-аас 2023 оны 10 дугаар сараас эхлэн БЭТ томилон ажиллуулж байна. 162 дугаар сургуулийн 20 багш, ажилтан 7		
--	--	--	--	--	--	---	--	--

							хоног бүрийн 1 өдөр 3-р сургуульд дээр орос хэлний сургалтад хамрагдаж, мэдлэг чадвараа дээшлүүлж, хамтран ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
1.1.1 1	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулах, төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлнэ.	2024 оны батлагдсан төсөв	Батлагдсан төсөл, хөтөлбөр	2023 оны төсөл, хөтөлбөр	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.	-Боловсрол, шинжлэх ухааны яам, Япон улсын Шинагава дүүрэг, “ЖАЙКА” Олон улсын хамтын ажиллагааны байгууллагатай хамтран ажиллах Санамж бичигт гарын үсэг зурах арга хэмжээ, бэлтгэл ажлыг зохион байгуулж талууд хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурсан. -Монгол Улсын Ерөнхийлөгч Ухнаагийн Хүрэлсүхийн урилгаар БНБУ-ын Ерөнхийлөгч А.Г.Лукашенко Монгол Улсад 2024 оны 06	100%	100%

						дугаар сарын 01-04-ний өдрүүдэд төрийн айлчлал хийх болсонтой холбогдуулан хамтран ажиллах 4 баримт бичгүүдийг боловсруулах, орчуулах, холбогдох байгуллагуудад илгээж, хянуулах ажлыг хийж гүйцэтгэлээ. - ОМӨЗО-ны Засгийн газрын тэтгэлэгт оюутны тоог 20-оор нэмэгдүүллээ. - Pearson English хөгжлийн хөтөлбөр хэрэгжиж, 70 сая евро төсөл эхлүүлэх ажлыг бэлтгэл ажлыг ханган ажилласан. Кембрижийн сургалтын хөтөлбөрийг 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх болон ЕБС-д хэрэгжүүлэхээр болсон. Монгол оюутнуудад олгох Chevening		
--	--	--	--	--	--	---	--	--

							тэтгэлгийн квотыг 7+10 буюу 17хүртэл нэмэгдүүлсэн. - Финландын “Neureka” төвтэй хамтран ажиллах, Монголд баригдаж буй шинжлэх ухааны паркийн музей, хүүхэд залуучуудад зориулсан шинжлэх ухааны туршилтын төвийг байгуулахад зөвлөх үйлчилгээ авахаар тохирлоо. Эстони Улстай дунд сургуулийн ахлах багш, сургуулийн менежер харилцан солилцох хөтөлбөр хэрэгжүүлэх талаар ярилцлаа. Эстонийн боловсролын чанарын баталгаажуулалтын НАКА /Estonian Quality Agency for Education/ байгууллагатай хамтран ажиллах хүсэлтээ албажуулж		
--	--	--	--	--	--	--	---	--	--

						хүргүүлэхээр боллоо. Гэрээ, хэлэлцээрийн хүрээнд үргэлжлэх: 1. 2023-2024 оны хичээлийн жилд 18 тэтгэлэгт хөтөлбөрт 1200-1300 Монгол Улсын иргэд суралцаж байна. 2. Энэ хичээлийн жилд Гадаад улсын (БНХАУ, ОХУ, Польш, Вьетнам, Унгар, Чех, Лаос, Энэтхэг)-ын 260 оюутан дээд боловсролын байгууллагад суралцаж байна. 3. 120 оюутан нэмэлтээр сургах чиглэлээр (Киргиз, БНХАУ, БНСУ, ХБНГУ-DAAD) гэрээ байгуулсан буюу хэлэлцээрийн түвшинд байна. 4. Гадаад улсад суралцаж буй оюутнуудад амьжиргааны зардал шийдвэрлүүлж		
--	--	--	--	--	--	--	--	--

							ажилласан. Хавсралт: 1 файл		
1.1.1 2	Монгол улс, ХБНГУ хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тэмдэглэх арга хэмжээнийн төлөөлөгөөний хэрэгжилтийг хангаж ажиллах	2024 оны батлагдсан төсөв	Зохион байгуулсан арга хэмжээний тоо	2023 онд зохион байгуулсан Олон Улсын хурал, уулзалт	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	1. Олон Улсын хурал, уулзалт, сургалт, семинар зохион байгуулсан байна. 2. Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх- Амгалан /2024.05.15/ ХБНГУ-ын Боловсрол ба судалгааны Зүүн Европ, Өмнөд Кавказ, Төв Азийн хамтын ажиллагааны хэлтсийн дарга Флориан Франк тэргүүтэй 12 төлөөлөгчдийг хүлээн авч уулзсан уулзалтын бэлтгэл ажлыг ханган ажилласан. Уулзалтын үеэр хоёр орны боловсрол, шинжлэх ухааны хамтын ажиллагааны талаар санал солилцож ярилцсан. Тухайлбал Монгол-Германы хамтарсан ашигт малтмал,	100%	100 %

							технологийн их сургуулийн төсөл /GMIT/ мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад томоохон хувь нэмэр оруулсан талаар онцолж, Германы судалгааны сангаас хэрэгжүүлж буй “Хөгжиж буй улс орнуудын хөтөлбөр”-т Монгол Улсын судлаач, эрдэмтдийг хамруулах, хамтын ажиллагааг улам эрчимжүүлэх талаар санал солилцов. Монгол Улс болон ХБНГУ хооронд дипломат харилцаа тогтоосны 50 жилийн ойг тохиолдуулан Монгол Улсын Засгийн газраас 2024 оныг “Монгол-Германы боловсролын салбарын хамтын ажиллагааг		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							дэмжих жил” болгон зарласан. Үүнтэй холбоотойгоор боловсрол, шинжлэх ухааны салбарт хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, арга хэмжээний талаар хэлэлцлээ. МУИС-д ХБНГУ-ын Боловсрол, судалгааны яамны төлөөлөгчидтэй төрийн өмчит 6 их сургуулийн төлөөлөл бүхий илтгэгч нар оролцож, дугуй ширээний уулзалт амжилттай зохион байгуулагдсан. Хавсралт: 1 файл		
1.1.1 3	Засгийн газар, Боловсрол, шинжлэх ухаан яам хоорондын гэрээ, хэлэлцээрийн хүрээнд гадаад улсад оюутан суралцуулах үйл ажиллагааг зохион байгуулах	2024 оны батлагдсан төсөв	БШУ-ны сайдын тушаалын дагуу Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах оюутны тоо	2023 оны байдлаар хийгдсэн гэрээ, хэлэлцээр	Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	Яамны гадаад харилцааны бодлого, арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажилласан байна.	2024 онд Засгийн газар хоорондын гэрээний хүрээнд хэрэгжиж буй Бүгд Найрамдах Польш улс, Бүгд Найрамдах Казахстан улс, Бүгд Найрамдах Вьетнам улс, Бүгд Найрамдах Франц зэрэг улсуудын	100%	100%

						тэтгэлэгт хөтөлбөрт хамрагдах, сонгон шалгаруулах зар мэдээллийг боловсруулан байршуулж, Боловсролын зээлийн сантай хамтран сонгон шалгаруулалт ирүүлсэн материалын бүрдэл болон эссэг цахим системээр шалгаж холбогдох ЭСЯ-тай хамтран сонгон шалгаруулалтыг зохион байгуулсан. Шалгарсан иргэдийн мэдээллийг ЭСЯ-уудад хүргүүлж дараагийн арга хэмжээг авч ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд Бүгд Найрамдах Польш улсад-22, Бүгд Найрамдах Казахстан улсад-11, Бүгд Найрамдах Вьетнам улсад-9, Бүгд Найрамдах		
--	--	--	--	--	--	--	--	--

							Франц улсад-10 оюутан тус тус суралцахаар сонгон шалгаруулалатад тэнцлээ. -ОХУ-ын Эрхүүгийн Үндэсний Судалгааны Техникийн Их сургуульд 2024--2025 оны хичээлийн жилд цахилгаан эрчим хүч, усан цахилгаан станц, дулааны эрчим хүчний чиглэлээр бакалаврын сургалтад нийт 30 хүртэл оюутныг сонгон шалгаруулах бэлтгэл ажлыг хангаж, зарыг байршуулж, бүртгэлийн үйл ажиллагаа үргэжлүүлж байна. -БНХАУ-ын ӨМӨЗО-ны дээд боловсролын байгууллагуудад суралцаууах сонгон шалгаруулалтын талаар мэдээллийг иргэдэд ил тод		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						нээлттэй байршуулж, бүртгэлийг үргэлжлүүлэн зохион байгуулж байна. Энэхүү тэтгэлгээр 2024-2025 оны хичээлийн жилд 180 оюутныг сонгон шалгаруулж, тус улсад суралцуулна. - ОХУ-ын “Роснефть” Нээлттэй хувьцаат нийгэмлэгийн тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд И.М.Губкины нэрэмжит Оросын газрын тос, байгалийн хийн их сургууль болон Москвагийн олон улсын харилцааны их сургуулийн бакалаврын сургалтад нийт 10 оюутныг сонгон шалгаруулах ажлыг Гадаад харилцааны яамтай хамтран		
--	--	--	--	--	--	---	--	--

							зохион байгууллаа. Хоёр улсын Засгийн газрын тэтгэлэг болох "Чевнинг тэтгэлэг 2024-2025"-ын сонгон шалгаруулалтыг тус улсын Элчин сайдын яамтай хамтран амжилттай зохион байгуулж ажилласан. Бүгд Найрамдах Чех улсын Засгийн газрын 2024/2025 оны тэтгэлэгт хөтөлбөрийг 2 үе шаттайгаар амжилттай зохион байгуулав. Хавсралт: 1 файл		
1.1.1 4	Хоёр Улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадаас Монгол Улсад суралцах оюутныг тухайн улсын ЭСЯ, төлөөлөлтэй хамтран бүртгэж, холбогдох	2024 оны батлагдсан төсөв	БШУ-ны сайдын тушаалаар батлагдан, гадаад улсаас ирж суралцаж буй оюутны тоо	2023 онд суралцаж буй оюутны тоо	Суралцах оюутны судалгааг холбогдох байгууллагаас авч нэгтгэсэн байна.	БШУ-ны сайдын тушаалаар баталгаажсан байна.	Хоёр Улсын Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрийн дагуу гадаадаас Монгол Улсад суралцах оюутныг тухайн улсын ЭСЯ, төлөөлөлтэй хамтран бүртгэж, холбогдох зохицуулалтуудыг хийж байна. Төрийн өмчийн 6	100%	90%

	зохицуулалтуудыг хийх						дээд боловсролын байгууллагад үргэлжлэн суралцаж буй гадаад оюутны талаар мэдээллийг албан бичгээр хүлээн авч нэгтгэж байна. 2024-2025 оны хичээлийн жилд Монгол улсад суралцах гадаад оюутны жагсаалтыг нэгтгэн, БШУ-ны сайдын тушаал төлөвлөсөн болно.		
1.1.1 5	Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит тэтгэлэгийн сонгон шалгаруулалтыг зохион байгуулах, үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангаж ажиллах	2024 оны батлагдсан төсөв	Хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоо	2023 онд хамрагдсан суралцагчийн тоо	Бэлтгэл ажлыг хангасан байна.	БШУ-ны сайдын тушаалаар Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах иргэдийн жагсаалт батлагдсан байна.	БШУ-ны сайдын 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн тушаалаар батлагдсан ажлын хэсэгт орж ажилласан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэгт хөтөлбөр /2021-2024/ тэтгэлгийн үр дүн, хэрэгжилтийн талаар хяналт-шинжилгээ хийж,	100%	90%

							тайлан бэлтгэн БШУ-ын сайдад танилцуулсан. Монгол Улсын Ерөнхийлөгчийн нэрэмжит сургалтын тэтгэлэг нь 2021 оноос эхлэн хэрэгжсэн. Тус тэтгэлгийн бэлтгэл хөтөлбөрт 2021 онд 403 суралцагч, 2022 онд 302 суралцагч, 2023 онд 259 суралцагч хамрагдаж нийт 1.4 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Бэлтгэл хөтөлбөрийг амжилттай төгсөж, гадаадад бакалаврын хөтөлбөрт суралцах ерөнхий шаардлагыг хангасан суралцагчид тэтгэлэгт хамрагддаг бөгөөд 2022 онд 253 суралцагчдад 5.3 тэрбум төгрөг, 2023 онд 260 суралцагчдад 20.0		
--	--	--	--	--	--	--	--	--	--

							тэрбум төгрөг, нийт 513 суралцагчид 23.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Хавсралт: 1 файл		
1.1.1 6	Монгол Улсын Ерөнхий сайдын (Засгийн газрын) тэтгэлэгт хөтөлбөрийг зохион байгуулахад дэмжлэг үзүүлэх	2024 оны батлагдсан төсөв	Тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо	2023 онд тэтгэлэгт хамрагдсан суралцагчийн тоо	Бэлтгэл ажлыг хангасан байна.	Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах оюутны нэрс, жагсаалтаар батлагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 102 дугаар тогтоолын “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд гадаадын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах урилга авсан тэргүүлэх,	100%	100 %

							эрэлттэй мэргэжлээр суралцах Монгол улсын иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн тушаал боловсруулан батлуулж, удирдамж, ажлын төлөвлөгөөг гарган Боловсролын зээлийн санд хүргүүлсэн. Сонгон шалгаруулах ажил Боловсролын зээлийн сангийн даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулагдана.		
1.1.1 7	Боловсрол, шинжлэх ухааны салбарт гадаадын зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилтээр хэрэгжиж буй төслүүдийн үйл ажиллагааны уялдааг хангаж, дэмжлэг үзүүлж, хяналт тавьж ажиллах	2024 оны батлагдсан төсөв	Батлагдсан төсөл, хөтөлбөр	2023 оны төсөл, хөтөлбөр	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр олон улсын гэрээ, хэлэлцээр байгуулсан байна.	Салбарын болон яамны гадаад хамтын ажиллагааны чиглэлээр төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд мэргэжлийн дэмжлэг үзүүлсэн байна.	-Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх- Амгалан “НҮБ-ын Хүүхдийн Сан”- ийн Суурин Төлөөлөгч Эваристе Каусси Комлан нарын уулзалт Засгийн газар, UNICEF хоорондын үйл ажиллагааны 2024 оны төлөвлөгөөнд	100%	70%

						гарын үсэг зурах үйл ажиллагааг зохион байгуулсан. 2024 оны төлөвлөгөөнд алслагдсан орон нутгийн малчдын хүүхдүүд, ядуу өрхийн болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүд СӨБ-ын чанартай үйлчилгээнд хамрагдах, өсвөр үеийнхэн сэтгэцийн хувьд эрүүл байх, тэдний хөдөлмөр эрхлэлтийг дэмжих, идэвхтэй иргэн байхад нь шаардагдах хөрвөх чадварыг олж авах эрүүл, аюулгүй орчныг бүрдүүлэх, Хүүхэд, өсвөр үе, эмэгтэйчүүдийг хоол тэжээл, Хүүхэд хамгаалаллын асуудлууд гээд чухал асуудлууд төлөвлөгөөнд орж байна. - Төслүүдийн талаар нэгдсэн мэдээлэл,		
--	--	--	--	--	--	---	--	--

							төслийн нэгжийн ажилтнуудын мэдээллийг нэгтгэн гаргаж Сангийн яаманд хүргүүлсэн. - Монгол Улсын БШУЯ, Монос групп, Эм Зүйн Шинжлэх Ухааны их сургууль, БНСУ-ын Өмнөд Кёнсон муж, Ёндок аймаг, Дэгү Хааны их сургууль хамтын ажиллагааны 6 талт санамж бичиг байгуулах ажлыг зохион байгууллаа. Санамж бичгийн хүрээнд "Уламжлалт анагаах ухааны торгоны зам" олон улсын хамтын ажиллагааны төслийг хэрэгжүүлэх юм. Энэхүү төсөл нь улс хоорондын хөгжил дэвшил, соёл, боловсрол, шинжлэх ухааныг түгээн дэлгэрүүлэх, судалгаа инновацыг		
--	--	--	--	--	--	--	--	--	--

						дэмжих, хоёр улсын цаашдын уламжлалт анагаах ухааны хөгжлийг олон улсад таниулан сурталчлах ач холбогдолтой юм. -БОЛОВСРОЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ ЯАМНЫ ГАДААД ТОМИЛОЛТЫН ЗАРДАЛ, ХЭРЭГЖҮҮЛСЭН АЖИЛ, ХҮРСЭН ҮР ДҮН (2021- 2024 он) танилцуулга бэлтгэн, БШУ-ны сайд болон холбогдох газрын дарга нарт хүргүүлсэн. Танилцуулгад 2021-2024 онд БШУЯ-ны удирдлагуудын гадаад улсад хийсэн айлчлал, гадаад улс орны зочид төлөөлөгчдийг хүлээн авах, олон улсын уулзалт арга хэмжээ, гэрээ хэлэлцээрийн хүрээнд хэрэгжиж буй төсөл	
--	--	--	--	--	--	--	--

							хөтөлбөрүүд болон тэтгэлэгт хөтөлбөрүүдийн талаар мэдээлэл, видео бэлтгэсэн. Хавсралт: 3 файл		
1.1.1 8	Дэлхийн шилдэг их, дээд сургуульд бакалаврын түвшинд оюутан суралцуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх	2024 оны батлагдсан төсөв	Хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоо	2023 онд хөтөлбөрт хамрагдсан суралцагчийн тоо	Бэлтгэл ажлыг хангасан байна.	БШУ-ны сайдын тушаалаар Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр суралцах иргэдийн жагсаалт батлагдсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 102 дугаар тогтоолын “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”-ын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд гадаадын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах урилга авсан тэргүүлэх, эрэлттэй	100%	90%

						мэргэжлээр суралцах Монгол улсын иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн тушаал боловсруулан батлуулж, удирдамж, ажлын төлөвлөгөөг гарган Боловсролын зээлийн санд хүргүүлсэн. Сонгон шалгаруулах ажил Боловсролын зээлийн сангийн даргын баталсан удирдамжийн дагуу зохион байгуулагдана. Хавсралт: 3 файл		
1.2.	Боловсрол, шинжлэх ухааны хууль тогтоомжид заасан эрх зүйн актыг боловсруулж, батлуулах, хэрэгжилтэд мэргэжил арга зүйгээр хангах, олон нийтэд сурталчлан	-	Журмын төсөл боловсруулан, батлуулсан байна.	-	-	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны “Журам шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт оруулах тухай” 102 дугаар тогтоолын “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад	100%	90%

	таниулах ажлыг зохион байгуулах						суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам"-ын хүрээнд 2024-2025 оны хичээлийн жилд гадаадын сургалтын байгууллагад бакалаврын үндсэн хөтөлбөрт суралцах урилга авсан тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцах Монгол улсын иргэдийг сонгон шалгаруулах ажлын хэсгийн тушаал боловсруулан батлуулж, удирдамж, ажлын төлөвлөгөөг гарган Боловсролын зээлийн санд хүргүүлсэн.		
1.2.1	Засгийн газрын 2022 оны 346 дугаар тогтоолоор батлагдсан	-	Журмын төсөл боловсруулсан байна.	-	Журмын төслийг бусад яамдуудад хүргүүлэн,	Журам батлагдан гарсан байна.	Монгол Улсын Засгийн газрын 2024 оны "Журам шинэчлэн батлах, тогтоолд өөрчлөлт	100%	90%

	“Боловсролын Зээлийн сангийн хөрөнгийг зарцуулах, түүнд хяналт тавих журам”-ыг шинэчлэн боловсруулах, Боловсролын зээлийн санг Боловсролын хөгжлийн сан болгон хөгжүүлэх хуулийн төсөл, хуулийн төслийн үзэл баримтлалын төсөл, Мэргэжлийн болон техникийн боловсролын сургалтад иргэдийг гадаад улсад суралцахад дэмжлэг үзүүлэх талаар холбогдох хууль тогтоомжид тусгах, санал боловсруулах				санал авсан байна.		оруулах тухай” 102 дугаар тогтоолын “Гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, буцалтгүй тусламж олгох, дэмжлэг үзүүлэх журам”-ын төсөлд санал өгч, холбогдох газар хэлтсүүдтэй хамтран ажилласан.		
Гурав. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээ									
3.1.	Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж	-	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж	2023 оны хэрэгжилт	-	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж	100%	100%	

	ажиллах		батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн байдал				батлуулан, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.		
3.1.1	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг	-	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг	2023 оны боловсруулс ан баримт бичгийн тоо	-	-	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлтийг сар бүр, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт-30, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон	100%	100 %

	тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх		тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлсэн байдал				хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлж ажилласан.		
3.1.2	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг	-	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн байдал	2023 оны хэрэгжилт	-	-	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн дагуу ахивын нэгж бүрдүүлэн өгсөн. Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан 44 өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн дагуу хугцаанд нь шийдвэрлэн ажилласан. Нийт 487 ирүүлсэн бичгийг шийдвэрлэж, 425 албан бичгийг бусад байгууллагад явуулсан байна. Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг	100%	90%

	хэрэгжүүлэх						сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажилласан.		
--	-------------	--	--	--	--	--	---	--	--

Үнэлсэн:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

.....

(огноо)

/...../

Тайлагнасан:

.....

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

.....

(огноо)

/...../